



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/68

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.8, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.14 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах, нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн бодлого шийдвэрийг иргэдэд түргэн шуурхай сурталчлахад зориулж 5750000 /таван сая долоон зуун тавин мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2020 оны
...*02*... дугаар сарын ...*14*... өдрийн ...*А/С*...
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Тоног төхөөрөмжийн нэр	Зориулалт	Тоо ширхэг	Үнэ /төгрөг/
1	Mevo plus camera	Шууд дамжуулах камер	1	3150000
2	Iphone XI	Камерын мик, программыг суулгаж ажиллуулах	1	2600000
Нийт дүн				5750000